



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 06 сарын 12 өдөр

Дугаар А/40.

Улаанбаатар хот

Стандартын үзлэг зохион байгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.5, нийслэлийн Засаг даргын 2014 оны А/449 дүгээр захирамж, тус газрын дүрмийн 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа амралтын газар, жуулчны бааз, гэр буудлуудыг стандартын үзлэгт хамруулах ажилд тус газрын мэргэжилтнүүдийг оролцуулж, мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллахыг ахлах мэргэжилтэн /Д.Ганболд/-д даалгасугай.

2. Стандартын үзлэг зохион байгуулахад шаардагдах төсөв 600,000 /зургаан зуун мянган/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Э.БАТТУЛГА